

УЛААНБААТАР ХОТ

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК
/хаалттай/“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн
2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн
172 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралт

8184062 А ХНТ9663

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2025 оны 03 дугаар улирлын байдлаар/**

2025 оны 09 дүгээр сарын 18

Багануур дүүрэг

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо					Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр			Өргөдлийн төрөл				
			Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	1-10 хоногт	11-20 хоногт	21-30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо	Албан бичгээр	Утсаар	Биечлэн уулзах	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Ажил хүссэн	3			3							+			+		
2	Дэмжлэг туслалцаа хүссэн																
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой																
4	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл	2			2							+			+		
5	Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл																
6	Бусад																
	Нийт	5			5							5			5		

Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

№	Ангилал	Тоо	Шалтгаан, тайлбар
0	1	2	3
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	5	Ажлаас гарах 1, ажилд орох 3, ээлжийн амралтын хугацаа тодруулах 1 хүсэлтийг тухай бүрт нь шуурхай шийдвэрлэсэн.
2	Боломжгүй тухай хариу өгсөн	-	-
3	Бусад	-	-

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ХК-д ИРГЭД,
АЛБАН ХААГЧДААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2025 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2025 оны 09 дүгээр сарын 18

Багануур дүүрэг

1.Манай байгууллагад 2025 оны 03 дугаар улиралд 1 албан хаагч ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж, 3 иргэн ажилд орох, 1 албан хаагч ээлжийн амралтын хугацаа тодруулах өргөдөл ирүүлсэн нь өмнөх оны тухайн үеийнхээс нэр төрлийн хувьд ялгаатай, тооны хувьд олон байна.

5 өргөдлийг өдөрт нь албан хаагчийн хүсэлт ёсоор, "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн 5 өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтлөн, өргөдөл болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад бэлтгэв.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

2.Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

3.Бүтээлч санал санаачлагын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэхүү уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. 2025 оны 03 дугаар улирлын байдлаар байгууллагын удирдлага нийт 15 иргэнтэй уулзаж, хүсэлтийг зохих ёсоор, үр дүнтэй шийдвэрлэсэн байна.

3.1.Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачлагын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилготой ажилладаг. Тайлант хугацаанд:

- "Натур ларикс вүүд" ХХК нь Багануур дүүргийн 3 дугаар хороонд мод бэлтгэлийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үндсэн түүхий эд болон үйлдвэрлэлийн явцаас хаягдах түүхий эд материалаар зиг-заг хавтан, модны үртсэн блок, тавилгын үйлдвэр зэрэг чиглэлээр цогц кластер үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой. Паркийн хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд нэгжээр элсэхээр хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Кластер үйлдвэрийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил явагдаж байна.

"Багануур мах маркет" ХХК нь малын махаар бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд өдөрт 200 бод, 1000 бог төхөөрч, боловсруулах хүчин чадалтай экспортын чиглэлтэй үйлдвэр юм. Үйлдвэрлэлийн явцаас хаягдах дайвар түүхий эдэд тулгуурлан Паркийн хүнсний үйлдвэрлэлийн бүсэд дайвар боловсруулах, яс боловсруулах, малын тэжээл бэлтгэх, муур нохойн хоол үйлдвэрлэх зэрэг экспортын үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэхээр хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Кластер үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил явагдаж байна.

- Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсэд "Трее Треелинг ойл" ХХК, хүрэн нүүрснээс синтетик газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх мөн хагас коксжуулсан нүүрс, байгалийн газ үйлдвэрлэхээр 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Дээрх 3 үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хянан баталгаажуулсны дараа Паркийн нэгжийн удирдлагатай байгуулах гэрээ, Паркийн нэгжид газар ашиглуулах гэрээ байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

4.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт улирал бүр нээлттэй байршуулдаг.

5.Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БЯМБАЦЭЦЭГ



ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН М.МӨНХДУЛАМ